



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СБА-2025/075-НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт сум

2025 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер: М.Нарантуяа

Утас: 99029193 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Миндүг аудит ХХК-ийн

Аудитор: Б.Бүзмаа

Утас: 91160110 Цахим хаяг: info@mindug.mn

Гүйцэтгэх захирал: С.Энхтөр

Утас:95957791 Цахим хаяг: director@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....</b>	<b>5</b>
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>10</b>
<b>3.1 Албан шаардлага .....</b>	<b>10</b>
<b>3.2 Зөвлөмж .....</b>	<b>10</b>
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>11</b>

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

---



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,  
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,  
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075  
Утас: (976) 70518396  
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.02.25 № 154

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

2024 оны 09-р сарын 13-нд 3,908.2 сая төгрөгийн өртөг бүхий 100 хүүхдийн дотуур байр ашиглалтад хүлээн авсаныг санхүүгийн тайлан, тодруулгад илэрхийлсэн байна.

### Аудитын гол асуудал

Тайлант оны эцэст буюу 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдөр БЯ-аас 35.1 сая төгрөгийн санхүүжилтийг цалин хөлс нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд хуваарилсан зарцуулалт хийгээгүй, үлдэгдэл 222.8 сая төгрөгийг мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлээр тайлагнасан, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 169.9 хувь өссөн байна. Иймд боловсролын байгууллагын дээд шатны төсвийн захирагчийн цалингийн төсвийн төлөвлөлт, үлдэгдэлд дүн шинжилгээ хийх шаардлагатай байна.

## **Бусад асуудал**

Санхүүгийн тайланд 213.9 сая төгрөгийн анхны өртөгтэй 38 ширхэг элэгдлийн зардлаараа анхны өртөгөө нөхсөн хөрөнгө байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is stylized and appears to be 'Г. ДАВАА'.

Г. ДАВАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>232,032,247.79</b>	<b>414,760,073.57</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	131,055,639.18	222,767,869.56
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	131,055,639.18	222,767,869.56
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	131,055,639.18	222,767,869.56
31211	Төрийн сангийн харилцах	131,055,639.18	222,767,869.56
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	6,821,375.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	6,821,375.00	-
3351	Байгууллагаас авах авлага	6,821,375.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	94,155,233.61	191,992,204.01
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	420,500.00	106,400.00
35110	Тусгай зориулалттай материал	420,500.00	-
35130	Эм боох материал	-	106,400.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	93,734,733.61	191,885,804.01
35410	Бичиг хэргийн материал	370,000.00	442,000.00
35450	Барилгын засварын материал	120,000.00	120,000.00
35460	Хүнсний материал	320,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	92,924,733.61	191,323,804.01
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,240,155,145.37</b>	<b>6,549,073,945.02</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,240,155,145.37	6,549,073,945.02
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,199,482,145.37	6,508,700,945.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,281,969,158.80	6,658,444,972.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	- 361,378,957.12	- 473,392,559.72
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	277,101,628.00	334,707,973.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	- 95,984,416.08	- 147,842,454.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	115,991,300.00	171,780,300.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	- 47,451,437.56	- 63,882,155.75
39214	Бусад үндсэн хөрөнгө	105,993,190.00	105,993,190.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	- 104,194,300.48	- 104,544,300.52
39217	Ном	27,435,979.81	27,435,979.81
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	40,673,000.00	40,373,000.00
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	- 275,000.00	- 575,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	39,448,000.00	39,448,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,472,187,393.16</b>	<b>6,963,834,018.59</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>26,537,687.55</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	26,537,687.55	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	26,537,687.55	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,450,481.55	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	25,087,206.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	25,087,206.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,445,649,705.61</b>	<b>6,963,834,018.59</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,445,649,705.61	6,963,834,018.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	449,054,291.40	449,054,291.40
51101	Өмч: - төрийн	449,054,291.40	449,054,291.40
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,459,208,511.86	5,977,392,824.84
51210	Өмнөх үеийн үр дүн	1,372,207,117.16	1,459,208,511.86
51220	Тайлант үеийн үр дүн	87,001,394.70	4,518,184,312.98
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	537,386,902.35	537,386,902.35
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,472,187,393.16</b>	<b>6,963,834,018.59</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,533,208,386.20</b>	<b>6,617,604,134.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>87,610,786.20</b>	<b>4,558,772,734.50</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	87,610,786.20	4,558,772,734.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	87,610,786.20	4,558,772,734.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,986,600.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,568,750.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	84,055,436.20	4,558,772,734.50
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,445,597,600.00</b>	<b>2,058,831,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,274,991,500.00	1,850,674,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,274,991,500.00	1,850,674,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	170,606,100.00	208,156,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	170,606,100.00	208,156,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,446,206,991.50</b>	<b>2,099,419,821.52</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,446,206,991.50</b>	<b>2,099,419,821.52</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,367,454,312.21	2,027,764,846.52
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	882,600,621.54	1,313,342,808.99
210101	Үндсэн цалин	607,199,117.49	857,422,795.65
210102	Нэмэгдэл	236,225,545.10	413,643,768.10
210104	Урамшуулал	39,175,958.95	42,276,245.24
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	98,371,209.13	193,283,900.92
210201	Тэтгэврийн даатгал	67,373,955.36	131,373,075.54
210202	Тэтгэмжийн даатгал	7,755,485.13	15,510,032.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,182,261.99	7,867,518.47
210204	Ажилгүйдлийн даатгал	1,548,036.35	7,706,614.91
210205	Эрүүл мэндийн даатгал	15,511,470.30	30,826,659.79
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	136,386,160.71	203,977,875.00
210301	Гэрэл, цахилгаан	13,801,479.71	12,468,321.48
210302	Түлш, халаалт	120,800,681.00	190,443,553.52
210303	Цэвэр, бохир ус	1,784,000.00	1,066,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	187,500.00
210401	Бичиг хэрэг	-	187,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	63,335,290.00	67,450,325.00
210502	Хоол, хүнс	63,335,290.00	67,450,325.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,000,000.00	11,000,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	11,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,136,000.00	9,225,655.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,986,600.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,149,400.00	9,225,655.17
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	168,625,030.83	229,296,781.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,259,680.00	36,678,559.09
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,202,400.00	11,665,863.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	125,162,950.83	180,952,359.35
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	78,752,679.29	71,654,975.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	61,354,115.00	71,654,975.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	61,354,115.00	71,654,975.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	17,398,564.29	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,398,564.29	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>87,001,394.70</b>	<b>4,518,184,312.98</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>87,001,394.70</b>	<b>4,518,184,312.98</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,449,152,950.00</b>	<b>2,058,831,400.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,555,350.00</b>	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,555,350.00	-
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	3,555,350.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,986,600.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,568,750.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,445,597,600.00</b>	<b>2,058,831,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,274,991,500.00	1,850,674,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,274,991,500.00	1,850,674,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	170,606,100.00	208,156,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	170,606,100.00	208,156,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,299,619,128.12</b>	<b>1,945,856,169.62</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,299,619,128.12</b>	<b>1,945,856,169.62</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,220,445,948.83</b>	<b>1,874,621,694.62</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	882,600,621.54	1,327,250,591.46
210101	Үндсэн цалин	607,199,117.49	871,666,393.84
210102	Нэмэгдэл	236,225,545.10	413,307,952.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	39,175,958.95	42,276,245.24
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	96,920,727.58	180,826,600.00
210201	Тэтгэврийн даатгал	65,923,473.81	122,962,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,755,485.13	14,466,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,182,261.99	7,233,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,548,036.35	7,233,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,511,470.30	28,932,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	143,207,535.71	197,156,500.00
210301	Гэрэл, цахилгаан	13,801,479.71	12,468,321.48
210302	Түлш, халаалт	127,622,056.00	183,622,178.52
210303	Цэвэр, бохир ус	1,784,000.00	1,066,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	63,655,290.00	67,130,325.00
210502	Хоол, хүнс	63,655,290.00	67,130,325.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,000,000.00	11,000,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	11,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,126,500.00	29,194,201.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,986,600.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,139,900.00	29,194,201.17
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	13,935,274.00	62,063,476.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,725,474.00	47,294,776.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,209,800.00	14,768,700.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,173,179.29	71,234,475.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	61,774,615.00	71,234,475.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	61,774,615.00	71,234,475.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,398,564.29	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,398,564.29	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	149,533,821.88	112,975,230.38
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	58,478,006.00	21,263,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	58,478,006.00	21,263,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	58,478,006.00	21,263,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	58,478,006.00	21,263,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	- 58,478,006.00	- 21,263,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	91,055,815.88	91,712,230.38
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	39,999,823.30	131,055,639.18
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	131,055,639.18	222,767,869.56

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	449,054,291.40	537,386,902.35	1,372,207,117.16	2,358,648,310.91
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	449,054,291.40	537,386,902.35	1,372,207,117.16	2,358,648,310.91
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	87,001,394.70	87,001,394.70
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	449,054,291.40	537,386,902.35	1,459,208,511.86	2,445,649,705.61
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	449,054,291.40	537,386,902.35	1,459,208,511.86	2,445,649,705.61
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	449,054,291.40	537,386,902.35	1,459,208,511.86	2,445,649,705.61
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	4,518,184,312.98	4,518,184,312.98
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	449,054,291.40	537,386,902.35	5,977,392,824.84	6,963,834,018.59

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн	Үзүүлэлт	Тайлант оны
-------	----------	-------------

засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,189,886,500.00	1,967,119,169.62
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,189,886,500.00	1,967,119,169.62
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,106,159,300.00	1,895,884,694.62
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,498,684,400.00	1,327,250,591.46
210101	Үндсэн цалин	958,546,600.00	871,666,393.84
210102	Нэмэгдэл	516,675,300.00	413,307,952.38
210104	Урамшуулал	23,462,500.00	42,276,245.24
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	187,335,400.00	180,826,600.00
210201	Тэтгэврийн даатгал	127,388,200.00	122,962,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,986,700.00	14,466,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,493,400.00	7,233,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,493,400.00	7,233,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	29,973,700.00	28,932,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	197,156,500.00	197,156,500.00
210301	Гэрэл, цахилгаан	17,500,000.00	12,468,321.48
210302	Түлш, халаалт	166,459,400.00	183,622,178.52
210303	Цэвэр, бохир ус	13,197,100.00	1,066,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	92,051,600.00	67,130,325.00
210502	Хоол, хүнс	92,051,600.00	67,130,325.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	11,000,000.00	11,000,000.00
210604	Урсгал засвар	11,000,000.00	11,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	32,300,200.00	29,194,201.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	32,300,200.00	29,194,201.17
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	87,631,200.00	83,326,476.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,862,500.00	68,557,776.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,768,700.00	14,768,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	83,727,200.00	71,234,475.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	83,727,200.00	71,234,475.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	83,727,200.00	71,234,475.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,058,831,400.00	2,058,831,400.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,058,831,400.00	2,058,831,400.00
122005	Орон нутгийн төсвөөс	2,058,831,400.00	2,058,831,400.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	131,055,639.18
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	222,767,869.56

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 28.6 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил<sup>1</sup> илэрснээс, 3.7 сая төгрөгийн 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгч, 24.9 сая төгрөгийн алдааг залруулсан. Илрүүлсэн 3,7 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

#### **3.1 Албан шаардлага**

##### **Илрүүлэлт:**

Нийт 2 албан хаагчид нийт 3,726.9 мянган төгрөгийн цалингийн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг давхардуулан олгосон зөрчилтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлтийн 16.5.5 (батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах), 41 дүгээр зүйлийн 41.2.2 (батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах), 41.2 дахь хэсгийн 41.2.3 (төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах), Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6 (харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх), Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1 (Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно), 12.1.4 (хуулиар зөвшөөрөөгүй бусад), Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан (Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын хавсралт), 2023 оны 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан (Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх) журмыг тус тус зөрчсөн байна.

#### **3.2 Зөвлөмж**

##### **1. Илрүүлэлт**

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 38 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2 (Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2 (Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна), үүнд 6.2.1 (Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон), “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## Өгсөн зөвлөмж

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан тогтоох асуудлыг судлан, элэгдлээрээ бүрэн нөхөгдсөн хөрөнгийг ашиглалтын боломжит байдлыг харгалзан дахин үнэлэх асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх, Мөн шаардлагатай тохиолдолд Орон нутгийн өмчийн газартай зөвшилцөн данснаас хасах шийдвэрийг гаргуулах томьёолол бэлтгэн, санхүүгийн тайланд бодитой тусгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

## 2. Илрүүлэлт

Хүнсний бараа, материалыг 67.1 сая төгрөгөөр худалдан авахдаа хууль тогтоомжийн дагуу тендер зарлаагүй нь шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь (төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах), заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 (Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна), 31.2. (харьцуулалт), 31.3 дахь (гэрээ шууд байгуулах) зүйл заалттай нийцэхгүй байна.

## Өгсөн зөвлөмж

Төсвийн гүйцэтгэл, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу хэрэгжүүлж, тайлагнах хяналтыг сайжруулан, тендер шалгаруулалтыг хуульд заасан аргуудын хүрээнд зохион байгуулж, гэрээ байгуулах үйл явцыг ил тод, хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг давхардуулан олгосон	1	3,726.9			1	3,726.9		
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 38 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна	1						1	
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>3,726.9</b>			<b>1</b>	<b>3,726.9</b>	<b>1</b>	

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
67.1 сая төгрөгийн бараа материал тендер зарлалгүй шууд гэрээ хийн худалдан авсан	1				1	
Дүн	1				1	
Нийт дүн	1				1	